

**“ЭРҮҮЛ ХҮНС – ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**
(2019 оны жилийн эцсийн байдлаар)

№	Хөтөлбөрийн агуулга		Гүйцэтгэл		
1.	“Эрүүл хүнс – Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөр Засгийн газрын 2019 оны 52 дугаар тогтоол		Хөтөлбөрийн зорилго: Хүнсний аюулгүй байдлыг хангаж, Монгол хүн эрүүл байх нөхцлийг бүрдүүлэхэд оршино.		
2.	Санхүүжилтийн үүсвэр	эх	улсын болон орон нутгийн төсөв; олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусламж; гадаадын хөрөнгө оруулалт; Засгийн газрын тусгай сангийн хөрөнгө; хувийн хэвшил болон бусад эх үүсвэр.		
3.	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа		Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Хөтөлбөр нь 2019-2023 онд хэрэгжинэ.		
			Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: ГХЯ, ЭМЯ, СЯ, МХЕГ, БСШУСЯ, СХЗГ, НЭМҮТ, аймаг, нийслэлийн Засаг дарга, мэргэжлийн холбоод, ТББ болон бусад		
4.	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд		Хөтөлбөрийн хүрээнд 5 зорилт дэвшүүлсэн. Хүнсний хангамжийн тогтвортой, тэнцвэртэй байдлыг хангах, хүртээмжийг нэмэгдүүлэх; Хүнсний шим тэжээллэг чанарыг сайжруулах, зохистой хэрэглээг дэмжих; Хүнсний сүлжээний бүх шатанд түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах; Хүнсний боловсруулах салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлж, экспортын баримжаатай үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх; Хүнсний аюулгүй байдлыг хангах бүтэц, зохион байгуулалтын оновчтой тогтолцоог бүрдүүлэх, салбарын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх.		
5.	Зардал	Төсөв (Нийт шаардагдах)	Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нийт 149.2 тэрбум төгрөг шаардлагатай. Үүнээс: улсын төсөв – 8.68, орон нутгийн төсөв – 1.1, гадаадын зээл, тусламж 4.92, концесс – 56.72, бусад 77.84		
		Үүнд:	Төсөв /2019/	Гүйцэтгэл	Хувь
		Хөтөлбөр хэрэгжүүлэх зардал /сая төг/	0	0	0
6.	Хөтөлбөрийн зорилт:		Арга хэмжээний биелэлт: Хөтөлбөрийн 5 зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд 53 арга хэмжээ төлөвлөгдсөн.		
	Зорилт 1. Хүнсний хангамжийн тогтвортой, тэнцвэртэй байдлыг хангах, хүртээмжийг нэмэгдүүлэх;		Хүнсний хангамжийн тогтвортой байдлыг хангах, улирлын хамаарлыг бууруулах зорилгоор “Эрүүл хүнс – Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийг Засгийн газрын “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих”, “Хүнсний ногоо”, “Жимс жимсгэнэ” үндэсний хөтөлбөрүүдтэй уялдуулан хэрэгжүүлж байна. Тухайлбал, Махны чиглэлийн эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх зорилгоор ЖДҮХС-ийн захирлын 2019 оны А/77, А/81, А/117 дугаар тушаалуудаар арвин ашиг шимтэй махны үүлдрийн үхрийг эрчимжсэн технологиор өсгөж үржүүлэх 14 аймгийн 34 иргэн, аж ахуйн нэгжид нийт 5.92 тэрбум төгрөгийн зээлийг олгосон. Энэ арга хэмжээний үр дүнд махны чиглэлийн арвин ашиг шимт үхрийн тоо 2019 онд 33.7 мянга болж, өнгөрсөн онтой харьцуулахад 40 хувиар нэмэгдсэн.		

		<p>Нийслэл хот болон томоохон хот суурингийн ойролцоо сүүний чиглэлийн үхрийн аж ахуй эрхлэгч 18 аймгийн 45 иргэн, аж ахуйн нэгжид ЖДҮХС-гаас 2019 онд нийт 2.86 тэрбум төгрөгийн зээлийн дэмжлэгийг үзүүлсэн.</p> <p>“Нүүдэлчин агро” ХХК нь Франц улсаас сүү-махны чиглэлийн монбильярд цэвэр үүлдрийн 96 толгой гунжин үнээг оруулж ирсэн. Энэ арга хэмжээнд эрх зүйн болон мэргэжил арга зүйн зөвлөгөө үзүүлсэн.</p> <p>Монгол Улс, Беларусь Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрээр тус улсын Экспортын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр газар тариалангийн бүс нутагт 600 үнээ бүхий хэд хэдэн сүүний кластер аж ахуй байгуулах төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөж, тендерийн баримт бичгийг боловсруулж байна. Тендер шалгаруулалтыг 2020 онд зохион байгуулна.</p> <p>Хүнсний хангамжийн тэнцвэртэй байдлыг хангах, импортын хамаарлыг бууруулах зорилгоор дараах ТЭЗҮ болон техник туслалцааны төслийн саналыг боловсруулж, англи хэлэнд орчуулан 2020 оны 6 дугаар сарын 10-нд зохион байгуулсан “Эрүүл хүнс – Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн зөвлөлдөх уулзалтын үеэр гадаад улс, олон улсын байгууллагуудад танилцуулсан. Үүнд: Чихрийн манжингийн тариалан, элсэн чихэр боловсруулах үйлдвэрийн цогцолбор байгуулах ТЭЗҮ, Улаанбаатар хотод төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний хадгалалт, борлуулалтын цогцолбор байгуулах ТЭЗҮ, Монгол Улсад байгалийн нөхцөлд загас үржүүлэх, загас, загасан бүтээгдэхүүн боловсруулах нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх техник туслалцааны төсөл.</p> <p>Стратегийн хүнсний дотоодын хангамжийн тогтвортой, тэнцвэртэй байдлыг хангах, стратегийн хүнсний нийлүүлэлтийн улирлын хамаарал, үнийн хэт хэлбэлзлээс сэргийлэх, гадаад худалдааны түнш орны зорилтот зах зээлд стратегийн хүнсийг экспортлохыг дэмжих, стратегийн хүнсийг экспорлох, импортлох зөвшөөрөл олгох үйл явцыг шуурхай болгох зорилгоор Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох түр журмыг шинэчилж Засгийн газрын 2019 оны 329 дүгээр тогтоолоор батлуулсан.</p> <p>Нийслэлийн хүн амын махны хангамжийг тогтворжуулах, нийлүүлэлтийн улирлын хамаарлыг бууруулах зорилгоор Засгийн газрын 2018 оны 218 дугаар тогтоолын хүрээнд арилжааны банкны эх үүсвэрээр мах бэлтгэсэн дотоодын үйлдвэрт хүүгийн хөнгөлөлт үзүүлж, нөөцөлсөн махыг хөнгөлөлттэй үнээр худалдан борлуулах арга хэмжээг зохион байгуулсан. Арилжааны банкны шалгуурт тэнцсэн “Баатарууд Тэнгэр”, “Дархан мийт фүүдс”, “Сүхбаатар мах маркет” ХХК-иуд 4.0 мянган тн мах бэлтгэснийг нийслэлийн хүн амын хүнсний хэрэгцээнд 2019 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс нийлүүлж, нийслэлийн 8 дүүргийн хүнсний 137 дэлгүүрээр дамжуулан үхрийн ястай мах 7200 төг/кг, хонины ястай мах 6000 төг/кг, ямааны ястай мах 5500 төг/кг үнээр худалдаалсан нь зах зээл дэх жижиглэнгийн үнээс 16-45 хувиар хямд байв.</p>
	<p>Зорилт 2. Хүнсний шим тэжээллэг чанарыг сайжруулах, зохистой хэрэглээг дэмжих;</p>	<p>“Давс багатай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжье” аяныг 2019 онд улсын хэмжээнд зохион байгуулж, тус аянд хүнсний чиглэлийн 260 гаруй аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулав. Аянд хамрагдсан хүнс үйлдвэрлэгчид, нийтийн хоолны үйлчилгээ эрхлэгчид хоол, хүнсний бүтээгдэхүүнийхээ давсны агууламжийг 60 хүртэл хувиар бууруулж, нийгмийн хариуцлагын хүрээнд сургалт, сурталчилгаа зохион байгуулсан.</p> <p>“Ээжийн сонголт – Эрүүл хүнс” болон “Өглөөний цай” хөдөлгөөнийг зохион байгуулах удирдамж, хэрэгжилтийг зохицуулах ажлын</p>

		<p>хэсгийн бүрэлдэхүүнийг ХХААХҮ-ийн сайдын 2019 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А-329 дүгээр тушаалаар батлуулж, хөдөлгөөнүүдийн нээлтийг Дэлхийн хүнсний өдрийг тохиолдуулан Сүхбаатарын талбайд зохион байгуулав. Хөдөлгөөнүүдийг нийгмийн сүлжээг ашиглах зохион байгуулах бөгөөд хүнсний хэрэглээ, шим тэжээлийн боловсролыг дээшлүүлэх, зохистой хооллох дадлын төлөвшүүлэх чиглэлд хийгдсэн судалгааны ажлуудыг татан төвлөрүүлж байна. Эдгээр хөдөлгөөнийг 2020-2021 онд эрчимжүүлнэ.</p> <p>Хүнсний шим тэжээллэг чанарыг сайжруулах, зохистой хэрэглээг дэмжих зорилгоор дараах ТЭЗҮ болон техник туслалцааны төслийн саналыг боловсруулж, англи хэлэнд орчуулан 2020 оны 6 дугаар сарын 10-нд зохион байгуулсан “Эрүүл хүнс – Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн зөвлөлдөх уулзалтын үеэр гадаад улс, олон улсын байгууллагуудад танилцуулсан. Үүнд:</p> <p>Эрүүл мэндийг дэмжих үйлчлэлтэй хүнсний үйлдвэр байгуулах ТЭЗҮ, “Монгол үндэстний хоол” техник туслалцааны төсөл.</p>
Зорилт 3. Хүнсний сүлжээний бүх шатанд түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах;		<p>“Жимс, жимсгэнэ, хүнсний ногооны үйлдвэрлэлд хөдөө аж ахуйн зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх заавар”-г ХХААХҮ-ийн сайдын болон Эрүүл мэндийн сайдын хамтарсан А166/ А251 дүгээр тушаалаар батлуулсан. Зааврын дагуу хөдөө аж ахуйн зохистой дадал нэвтрүүлсэн хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийг хөндлөнгийн баталгаажуулалтын байгууллагууд баталгаажуулна.</p> <p>АХБ-ны Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд хүнсний аюулгүй байдлын стандартчиллыг боловсронгуй болгох төслийн хүрээнд гадаадын экспертнийг урьж 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдөр сургалт зохион байгуулсан. Сургалтад МХЕГ, ХАБҮЛЛ, УМЭАЦТЛ, ШУТИС, ТДС, МХХ, ММХ зэрэг байгууллагын 30 гаруй хүнийг хамруулж, хүнсний боловсруулах салбарт үйлдвэрлэлийн зохистой дадал, НАССР нэвтрүүлэх талаар мэдээлэл, зөвлөгөө өгсөн.</p> <p>Хүнсний боловсруулах салбарт Үйлдвэрлэлийн зохистой дадал /GMP/ хялбаршуулан нэвтрүүлэх зааврын төслийг боловсруулж, төслийн хэлэлцүүлгийг дотоодын хүнс үйлдвэрлэгчид, мэргэжлийн холбоодыг оролцуулан 2019 оны 12 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулж гарсан саналыг нэгтгэсэн. Зааврын төслийг эцэслэн боловсруулж, батлуулахад бэлэн болгосон.</p> <p>Үндэсний хөтөлбөрийн хүрээнд ХХААХҮЯ-наас НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага болон ДЭМБ-тай хамтран “Хүнсний хяналтын тогтолцоог боловсронгуй болгох” техник туслалцааны төслийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэж, төслийн нээлтийн семинарыг 2019 оны 4 дүгээр сарын 30-нд зохион байгуулсан.</p> <p>Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль болон Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлийн тухай хуульд тогтоомжид нийцүүлэн Махны үйлдвэрлэл, худалдааны мөрдөх техникийн зохицуулалтын төслийг шинэчлэн боловсруулсан. Тус зохицуулалтын төслийг 2020 оны 2-3 дугаар улиралд Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.</p> <p>Монгол Улсын стандартын улсын үзлэгийн дүнгээр хүнсний салбарт 652 стандарт мөрдөгдөж байна. Хүнсний салбарт 2019 онд дараах стандартуудыг батлуулав. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • “Зайрмаг техникийн ерөнхий шаардлага” стандарт. • “Хоолны газрын нэр томъёоны тодорхойлолт” стандарт. • “Хоолны газарт тавигдах шаардлага” стандарт. • “Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ” стандарт. • Баяжуулсан буудайн гурил техникийн ерөнхий шаардлага.

		<ul style="list-style-type: none"> • Буудайн гурилыг баяжуулагч бэлдмэл. Техникийн ерөнхий шаардлага. • Хүнсний зориулалтын иоджуулсан давс. Техникийн ерөнхий шаардлага. <p>Кодексийн үндэсний зөвлөлийг бэхжүүлэх, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах зорилгоор www.codexmongolia.com хуудсыг бий болгох ажлын даалгаврыг боловсруулсан. Энэ ажлыг ХХААХҮЯ-наас НҮБ-ын ХХААБ болон ДЭМБ-тай хамтран хэрэгжүүлж байгаа техник туслалцааны төслийн хүрээнд 2020 онд хэрэгжүүлнэ.</p> <p>Худалдааны тухай хуулийн төслийг боловсруулж, төслийн хэлэлцүүлгийг 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр зохион байгуулав. Хэлэлцүүлэгт худалдааны салбарын холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшлийн төлөөлөл 150 гаруй хүн оролцуулж, хэлэлцүүлгээс гарсан саналыг тусгасан.</p> <p>Махны нэмүү өртгийн сүлжээнд мал төхөөрөх үйл ажиллагаа эрхлэх хэсэгт эрх зүйн зохицуулалт сул байгаа тул хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, мал, мах бэлтгэн нийлүүлэлтийн оновчтой тогтолцоог бүрдүүлэх, малын дайвар бүтээгдэхүүний ашиглалтыг сайжруулах зорилгоор мал төхөөрөх үйлдвэрлэл эрхлэх асуудлыг аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлөөр зохицуулах саналыг боловсруулж, Зөвшөөрлийн тухай хуулийн төсөлд тусгуулахаар хүргүүлсэн.</p> <p>Сүүн үйлдвэрлэлийн технологийн шат дамжлага дахь хорогдлын нормыг тогтоох судалгааны ажлыг “Хоршоологчдын ертөнц” ТББ-аар гэрээгээр гүйцэтгүүлж, судалгааны тайланг 2019 оны 12 дугаар сард хүлээн авсан.</p>
	<p>Зорилт 4. Хүнсний боловсруулах салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлж, экспортын баримжаатай үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх;</p>	<p>Монгол Улс Евразийн эдийн засгийн холбоо /ОХУ, Казакстан, Беларус, Армен, Киргизстан/ болон БНСУ-тай Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах хамтарсан судалгааны шатанд байна. БНСУ-тай Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах шинжээчийн багийн бүрэлдэхүүнд багтаж, барааны худалдааны хэлэлцээрт хүнсний бүтээгдэхүүний тарифын хөнгөлөлттэй нөхцөлийг тусгах чиглэлээр ажиллаж байна.</p> <p>БНХАУ-ын эрх бүхий байгууллагын экспертүүдийг урьж дотоодын дараах хүнсний үйлдвэр, аж ахуйд хянан магадлагаа хийлгэх ажлыг зохион байгуулав. Үүнд: 2019 оны 05 дугаар сарын 29-нээс 06 дугаар сарын 11-ний хооронд гурилын 13 үйлдвэрт, 2019 оны 11 дүгээр сарын 06-наас 12-ны өдрийн хооронд сүү боловсруулах 4 үйлдвэр, сүү хүлээн авах 1 цэг, сүүний эрчимжсэн 2 аж ахуйд. БНХАУ-тай хорио цээрийн протокол байгуулахаар бэлтгэж, дээр дурдсан хянан магадлагааны хариу хүлээгдэж байна.</p> <p>Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга тэргүүтэй төлөөлөгчид Вьетнам болон Лаос улсад 2019 оны 2 дугаар сарын 25-наас 3 дугаар сарын 01-ний өдрүүдэд ажиллав. Монгол, Вьетнамын Засгийн газар хоорондын комиссын 16 дугаар хуралдаанаар тохиролцсоны дагуу Монгол Улсаас тус улсад гүн хөлдөөсөн хонь, ямаа, адуу болон үхрийн мах экспортлох талаар яриа хэлэлцээ хийж, мал эмнэлэг, эрүүл ахуйн гэрчилгээний загвар хүргүүлсэн. Монгол Улсаас мах импортлох асуудлаар Вьетнам улсын эрсдэлийн үнэлгээний баг ирж ажиллахаар тохиролцсон. Мөн Монгол, Лаос улсын Мал эмнэлгийн ерөнхий газар хооронд хамтран ажиллах хэлэлцээр байгуулав. Энэ хэлэлцээрийн дагуу манай улсаас Лаос Улсад гүн хөлдөөсөн мах, махан бүтээгдэхүүн экспортлох нөхцөл, боломж бүрдсэн.</p> <p>БНХАУ-ын эрх бүхий байгууллагын ажлын хэсэг манай улсад 2019 оны 12 дугаар сарын 12-21-нд хүрэлцэн ирж, манай улсын махны</p>

		<p>холбогдох үйлдвэрүүдтэй танилцаж, үнэлгээ өгөх ажлыг гүйцэтгэсэн. Хятадын талын ажлын хэсгийн хариуг хүлээж байна. Дэлхийн хүнсний өдрийг тохиолдуулан “Хүнсний аюулгүй байдал ба нэмүү өртөг шингэсэн хүнс экспортлох боломж, арга зам-2019” ЭШБХ-ыг уламжлан зохион байгуулав. Тус бага хуралд оюутны болон судлаачийн төрөлд нийт 33 судалгааны ажил ирүүлснийг шалгаруулж, урамшуулав. Үйлдвэрлэлд нэвтрүүлэх боломжтой судалгааны ажлуудыг Монголын хүнсчдийн холбоонд хүргүүлсэн. Жижиг дунд үйлдвэрийн тэргүүлэх ач холбогдол бүхий салбарын жагсаалт, чиглэлийг Засгийн газрын 2019 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 190 дүгээр тогтоолоор баталсан. Тэргүүлэх салбарын жагсаалтад сүү, сүүн бүтээгдэхүү, мах дайвар бүтээгдэхүүний үйлдвэрлэл, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ боловсруулах үйлдвэрлэл, харин тэргүүлэх чиглэлд хүнсний баяжуулах болон органик үйлдвэрлэл багтсан болно.</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах дотоодын үйлдвэрийн 14 бүлгийн 155 нэр төрлийн бүтээгдэхүүний жагсаалтыг боловсруулан Засгийн газрын 2019 оны 90 дүгээр тогтоолоор шинэчлэн батлуулж, дотоодын үйлдвэрүүд бүтээгдэхүүнээ төсвийн байгууллагын худалдан авалтад хамруулах нөхцөл, боломжийг бүрдүүлсэн.</p> <p>Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох түр журмыг шинэчлэн Засгийн газрын 2019 оны 329 дүгээр тогтоолоор батлуулж, хүнсний экспорт, импортын нэг цонхны бодлого хэрэгжүүлэх зохицуулалтыг тусгасан. Тухайлбал, нэг цонхны бодлогыг барааны гэрчлэх тэмдэг эзэмшигч мэргэжлийн холбоо, гадаад худалдаа эрхлэгч хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн байгуулсан нэгдэл /консорциум/ эсхүл төрийн өмчит хуулийн этгээд хэрэгжүүлж болно. Энэ бодлого зохицуулалтын үр дүнд хүнсний экспортын үр ашгийг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх боломж бүрдэнэ.</p> <p>“Алсыг харъя, органикийг сонгоё” сэдэвт нэг сарын аяныг холбогдох төрийн болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран 2019 оны 5 дугаар сарын 15-наас 6 дугаар сарын 15-ны хооронд зохион байгуулж Органик хүнсний тухай хууль тогтоомжийг олон нийт болон аж ахуйн нэгжүүдэд сурталчлах, бодитой мэдээлэл өгөх ажлыг хэрэгжүүлсэн.</p> <p>“Органик хүнс үйлдвэрлэгчдийн IV чуулган”-ыг 2019 оны 10 дугаар сарын 14-16-ны өдрүүдэд зохион байгуулж, органик хүнс үйлдвэрлэгч 200 гаруй төлөөлөгчдийг оролцуулав. Чуулганы үеэр Азийн бүтээмжийн байгууллагатай хамтарсан сургалтыг зохион байгуулж, органик хүнс үйлдвэрлэгчдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.</p>
	<p>Зорилт 5. Хүнсний аюулгүй байдлыг хангах бүтэц, зохион байгуулалтын оновчтой тогтолцоог бүрдүүлэх, салбарын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх.</p>	<p>Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн явц, тайлбар, авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг боловсруулж ҮАБЗ-ийн ажлын албанд хүргүүлсэн.</p> <p>Хүнсний аюулгүй байдлыг хангах бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, бие даасан агентлаг байгуулах, мөн хүнсний салбарт инноваци, шинэ технологи нутагшуулах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх үүрэгтэй Судалгаа хөгжлийн төвийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын хэлбэрээр зохион байгуулахаар судалж байна.</p> <p>Хүнсний салбарт хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх зорилгоор дараах техник туслалцааны төслийн саналыг боловсруулж, англи хэлэнд орчуулан 2020 оны 6 дугаар сарын 10-нд зохион байгуулсан “Эрүүл хүнс – Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн зөвлөлдөх</p>

		<p>уулзалтын үеэр гадаад улс, олон улсын байгууллагуудад танилцуулсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Хүнсний боловсруулах салбарын хүний нөөцийн чадавхийг сайжруулах. • Хүнсний боловсруулах салбарт төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах. <p>Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-д заасан “.. зохистой дадлын сургалт зохион байгуулах” чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоогоор гүйцэтгүүлэх санал боловсруулсан.</p> <p>Мөн НҮБ-ын ХХААБ болон ДЭМБ-тай хамтран хэрэгжүүлж байгаа “Хүнсний хяналтын тогтолцоог сайжруулах” техник туслалцааны төслийн хүрээнд Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах санал боловсруулж хүргүүлсэн.</p> <p>Хүнсний салбарын ажилтан ажиллагсад мэргэшлийн зэрэг олгох эрх зүйн үндсийг бүрдүүлэх зорилгоор Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулж ХЗДХЯ-тай хамтран 2019 оны 6 дугаар сард баталсан. Үзэл баримтлалын хүрээнд хуулийн төслийг боловсруулж байна.</p> <p>Монгол Улс хүнс экспортлогч орон болох стратегийн зорилтын хүрээнд хүнсний салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд хүний нөөцийн чадавхийг сайжруулах нь чухал ач холбогдолтой. Иймд хүнсний салбарт мэргэжилтэн бэлтгэдэг төрийн болон хувийн хэвшлийн 11 сургуулийг багтаасан консорциум байгуулах бодлогын арга хэмжээний саналыг боловсруулсан. Ажлын зөвлөлдөх уулзалтыг 2020 оны 1 дүгээр сард зохион байгуулна. Тус консорциумтай хамтран “Эрүүл хүнс – Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 55-59 дэх арга хэмжээг 2020 оноос хэрэгжүүлнэ.</p> <p>ХБНГУ-ын ЭЗЯ-ны шугамаар тус улсын Бавари мужид Монголын хүнсчдийн холбоотой хамтран “Хүнсний үйлдвэрлэл, хөдөө аж ахуй” сэдэвт сургалтад дотоодын 7 үйлдвэрийн төлөөллийг 2019 оны 8 дугаар сарын 11-18-нд хамруулсан.</p>
7.	<p>Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)</p>	<p>Дутагдал: Үйл ажиллагааны хүчин зүйл: “Эрүүл хүнс – Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийг Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 52 дугаар тогтоолоор баталсан бөгөөд уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг ХХААХҮ-ийн сайдын 2019 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А-406 дугаар тушаалаар (10 сарын дараа) батлуулсан. Төлөвлөгөө батлагдаагүйн улмаас удирдлага, зохион байгуулалт дутмаг байв.</p> <p>Хөтөлбөр хэрэгжүүлэхэд 149.2 тэрбум төгрөг шаардлагатай гэж төсөвлөсөн боловч санхүүжилтийн эх үүсвэр шийдэгдээгүй (Ирүүлсэн тайлангийн дагуу санхүүжилт тэгтэй тэнцүү).</p> <p>Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал харьяалах нутаг дэвсгэртээ “Эрүүл хүнс – Эрүүл Монгол хүн” дэд хөтөлбөр баталж, санхүүжилт шийдвэрлэн, хэрэгжилтэд нь хяналт тавих ёстой боловч уг ажил хангалтгүй байна.</p> <p>Төлөвлөлтийн алдаатай байдал: Дээрх хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөө нь Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолын хавсралт, “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын хавсралт, “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан суурь түвшин, суурь он, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг, хүрэх үр дүнг оноор нарийвчлан тусгаагүй байдалтай батлуулсан нь үр дүнгийн</p>

	<p>өөрчлөлтийг хэмжиж, бодит үнэлгээ өгөх боломж олгохгүй байна (Уг асуудлаар 2019 оны 5 сард дотоод албан бичгээр санал өгсөн болно). Тайлагналт хангалтгүй:</p> <p>Хөтөлбөрийг ГХЯ, ЭМЯ, СЯ, МХЕГ, БСШУСЯ, СХЗГ, НЭМҮТ, аймаг, нийслэлийн Засаг дарга, мэргэжлийн холбоод, ТББ зэрэг олох байгууллага хамтран хэрэгжүүлэхээр заасан боловч арга хэмжээ бүрээр холбогдох газраас тайланг авч нэгтгэхгүй практик зонхилдог нь тайлан бодитой бус, үр дүнг бус үйл ажиллагааг дараалуулан тоочсон, адил төстэй арга хэмжээний тайлангаар орлуулах, ирээдүйд болох таамаглал тусгах байдлаар тайлагнахад хүргэдэг.</p> <p>Анхаарах асуудал:</p> <ul style="list-style-type: none"> - “Эрүүл хүнс – Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг холбогдох журамд нийцүүлэн шинэчлэн боловсруулж, дахин батлуулах. - Хөтөлбөрийн орон нутаг дахь хэрэгжилтийг хангуулах чиглэлээр арга хэмжээ авах. - Тайлангийн чанар сайжруулах, оролцогч талуудаас тайлан авах, нэгтгэх, орон нутгийн түвшинд хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах чиглэлд мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллахыг Хүнсний үйлдвэрийн бодлого, зохицуулалтын газарт зөвлөмж болгов. 						
8	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Хөндлөнгийн үнэлгээ хийгээгүй болно.					
9	Өөрийн үнэлгээ	биелэлт	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4	Зорилт 5
		79.0 %	70.0	-	75.0	92.5	70.0
10	ЗГХЭГ-ын үнэлгээ	Нэгдсэн үнэлгээ					
		%					

Эрүүл хүнс - Эрүүл монгол хүн үндэсний хөтөлбөр

Д/д	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2019 оны зорилгот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Нэгдсэн дүгнэлт	Үнэлгээ
1. Хүнсний хангамжийн тогтвортой, тэнцвэртэй байдлыг хангах, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ						
1	1.1. Хот, суурин газрын ойролцоо мах болон сүүний чиглэлийн үхрийн эрчимжсэн аж ахуй эрхлэх, боловсруулах үйлдвэртэй хамтран ажиллахыг бодлого, арга зүйгээр дэмжих	2019 - 2023			Сүүний чиглэлийн эрчимжсэн аж ахуйнуудын бүтээгдэхүүн нийлүүлэлтийн төлөвлөлт хийж, үйлдвэрлэлийн улирлын хамаарлыг багасгаж, дотоодын шингэн сүүний үйлдвэрлэлийг өвлийн улиралд нэмэгдүүлж импортын хэмжээг багасгаж хүн амын өдөр тутмын хэрэгцээг чанартай, эрүүл ахуйн шаардлага хангасан бүтээгдэхүүнээр хангах явдал гэж үзэж байна. Харин зуны улирал дахь шингэн сүүний борлуулалтыг нэмэгдүүлэх чиглэлд сүү боловсруулах өндөр технологи нэвтрүүлэх, зээлийн дэмжлэг үзүүлэх зэрэг асуудлыг судалж үе шаттай хэрэгжүүлэх нь зүйтэй байна. Төв суурин газрын хүн амыг үйлдвэрийн аргаар боловсруулсан махаар хангах ажлыг нийслэлийн хэмжээнд 140 орчим, Дархан-Уул аймагт 100 гаруй худалдааны цэгээр тус тус худалдах ажлыг зохион байгуулсан. Сүүний урамшууллын журмын төсөл боловсруулах, хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хэсгийг яамны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны А-122 дугаар тушаалаар байгуулж ажиллаа. Энэхүү төслийг ХХААХҮ-ийн сайдын зөвлөлөөр хэлэлцүүлэн гишүүдээс гаргасан саналыг журмын төсөлд тусгаж ойрын хугацаанд Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар ажиллаж байна.	Үнэлэх боломжгүй
2	1.2. Хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, буурцагт ургамлын тариалалтыг нэмэгдүүлэх	2019 - 2023			Жимс жимсгэнэ, хүнсний ногоо тариалагчдын улсын анхдугаар зөвлөгөөнийг зохион байгуулав. Жимс жимсгэнэ” хөтөлбөрийн хүрээнд 2019 онд улсын төсвийн 147.4 сая төгрөгийн улсын төсвийн санхүүжилтээр суулгац үржүүлэх болон хүнсний ногоо тариалах 120 м2 талбай бүхий 38 иж бүрдэл нийлэг хальсан хүлэмж нийлүүлж, суулгацны үйлдвэрлэл 200.0 мянган ширхэгээр, хүлэмжийн талбай 3360 м2-аар нэмэгдэв. Ховд аймгийн Булган, Жаргалант суманд жимс жимсгэний суулгац үржүүлгийн төвийг байгуулав. Булган аймагт Шинэ хөдөө төслийн хүрээнд 239.2 сая төгрөгийн санхүүжилтээр 7	Үнэлэх боломжгүй

					суманд тус бүр 10 га талбай бүхий нийт 70 га талбайд жимс жимсгэний дуслын усалгааны төхөөрөмж нийлүүлж суурилуулав. Тус төслийн хүрээнд сүүлийн 2 жилд 8 суманд жимст цэцэрлэгийн талбай байгуулан нийт 50 мянган ширхэг чацаргана, 15.0 мянган ширхэг үхэр нүдний суулгац зээлээр олгон тариалуулж 11 сумын 150 га чацарганы талбайд орчин үеийн дэвшилтэт дуслын усалгааны систем суурилуулж усалгаажуулав. 2019 онд 519 аж ахуйн нэгж, 5289 иргэн 6528.2 га талбайд жимс жимсгэнэ тариалж 2604.1 тонн жимсний ургац хураан авсан байна. Энэ нь 2016 оноос тариалсан талбай 456 га талбайгаар, хураан авсан ургац 45 тонноор нэмэгдсэн байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд аймаг, орон нутгаас 3.7 тэрбум төгрөгийн хөрөнгө зарцуулж 410 ажлын байр шинээр бий болгож, 38.5 га байгалийн жимс жимсгэний талбайг нөхөн сэргээж, 7 төрлийн жимсний 515.3 мянган ширхэг суулгацыг дотооддоо үйлдвэрлэсэн байна. 2019 онд төмс 13.8 мянган га-д тарихаас 14.3 мян га-д, хүнсний ногоо 8.9 мянган га-д тарих зорилт 2018 оныхоос төлөвлөгөөг гаргаж аймгийн Засаг дарга нартай бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээг хийв. Төмс 14.9 мянган га-с 190.8 мянган тн, хүнсний ногоо 8.3 мянган га-с 98.6 мянган тн хураан авч төмсний хэрэгцээг 100 хувь, ногооны хэрэгцээг 40 хувь хангасан. 2019 онд 804 аж ахуйн нэгж, 16.0 мянган өрх хүнсний ногооны тариалан эрхлэв. Хүнсний ногооны 25 нэр төрлийг тариалсан байна.	
3	1.3. Тосны ургамал, чихрийн манжинг таримлын сэлгээнд нэвтрүүлэх	2019 - 2023			Хөдөө аж ахуйг дэмжих сангийн 2020 оны худалдан авах арга хэмжээний төлөвлөгөөнд сэлгээний болон тосны ургамлын тариалалтыг дэмжих зорилгоор 6 таримлын 2.4 тэрбум төгрөгийн үрийг дамжуулан зээлдүүлэх зарчмаар нийлүүлэхээр сонгон шалгаруулалтыг зарлаад байна. Дээрх үрийг нийлүүлснээр 60 орчи мянган га-д тосны болон тэжээлийн ургамал тариалах боломж бүрдэнэ.	Үнэлэх боломжгүй
4	1.4. Дотоодын загасны аж ахуйг дэмжих	2019 - 2023			Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийн төлөвлөгөөнд Монголын загас, усны амьтан үржүүлгийн холбоотой хамтран ажиллах чиглэлээр дотоодын загасны аж ахуйг дэмжих талаар нэлээд асуудлыг тусгаж батлуулсан. Загасны аж ахуй,	Үнэлэх боломжгүй

					хоршоо, иргэдийг 2019 онд бүртгэлжүүлсэн байна. Загасны аж ахуй эрхлэх, загас, загасан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэл эрхлэх тогтоосон бүсчилсэнд усан ай савын нөөцийн судалгааны ажлыг БОАЖЯамтай хамтран хийж байна. Загасны аж ахуйг 2021 оноос эхлэн дэмжиж ажиллахаар ЭМААХДҮХ-ийн төлөвлөгөөнд тусгагдсан.	
5	1.5. Махны чиглэлийн шувууны аж ахуйг дэмжих	2019 - 2023			Манай улсад махны чиглэлийн тахианы 1 аж ахуй үйл ажиллагаа эрхэлж байна. Тус үйлдвэрлэлийн тахианы тоо толгойн өсөлттэй холбоотойгоор махны үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдэж байна. Шувууны тэжээл үйлдвэрлэлийн 95 хувийг дотоодын 2 компаниуд хангаж байна. Тэжээл үйлдвэрлэгч нар дотоодын улаан буудай, хивэг, рапс, тос, мах ясны гурил, кальцийн чулуу зэргийг хэрэглэхээс гадна импортоор шарбуурцагны шах дас, эрдэнэ шиш худалдан авч байна. Тэжээл үйлдвэрлэл өсөх нөхцөлийг дотоодын компаниуд хангаж байна. 2018 онд шувууны бэлдмэл тэжээл 11215,4 тн-ийг импортолж байсан бол 2019 онд 3060,4 тн-ийг импортолж шувууны тэжээлийн импорт 3,6 дахин буурсан байна. 2019 онд ЖДҮХС-аас 4-н тахианы аж ахуй эрхлэгч иргэнд 200 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэгийг 5-н жилийн хугацаатай олгосон. Махны чиглэлийн тахианы аж ахуйг ХХААХҮЯ-ны зүгээс мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр байнга хангаж байгаа бөгөөд 2020 онд санхүүгийн дэмжлэг үзүүлэхээр төлөвлөж байна.	Үнэлэх боломжгүй
6	1.6. Өндөгний үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалтыг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг зохицуулах	2019 - 2023			Төлөвлөгөөнд тусгагдсан хугацаа болоогүй.	Үнэлэх боломжгүй
7	1.7. Байгаль, цаг уурын онцлогоос шалтгаалан дотоодын үйлдвэрлэл хязгаарлагдмал цагаан будаа, элсэн чихэр зэрэг бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой, тэнцвэртэй байдлыг хангахад гадаад худалдааны түнш орнуудтай яриа хэлэлцээ хийх	2019 - 2023			БНСУ-тай Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах судалгааны шатанд тус улсаас цагаан будаа импортлох тарифыг хөнгөвчлөх санал боловсруулж байна.	Үнэлэх боломжгүй

8	1.8. Дотоодын хүнсний үйлдвэрлэлийг дэмжих тарифын болон тарифын бус зохицуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх	2019 - 2023			1. Үйл ажиллагааны төлөвлөлт зөв. 2. Журам бол тарифын бус зохицуулалтын арга хэмжээ юм. Шинэчилсэн бөгөөд шинэ арга бол биш. 3. Тайлан дутуу. Тарифын ямар арга хэмжээ авсан тухайгаа нэмж тайлагнах шаардлагатай.	70%
9	1.9. Хөдөө аж ахуйн түүхий эд бэлтгэл, тээвэр-логистикийн сүлжээ байгуулах хувийн хэвшлийн санаачилгыг дэмжих	2019 - 2023			Төлөвлөгөөнд тусгагдсан хугацаа болоогүй.	Үнэлэх боломжгүй
10	1.10. Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх арга хэмжээг орон нутагт хувийн хэвшлийн оролцоотой зохион байгуулах	2019 - 2023			Нийслэлийн хүн амын махны хангамжийг тогтворжуулах, нийлүүлэлтийн улирлын хамаарлыг бууруулах зорилгоор Засгийн газрын 2018 оны 218 дугаар тогтоолын хүрээнд арилжааны банкны эх үүсвэрээр мах бэлтгэсэн дотоодын үйлдвэрт хүүгийн хөнгөлөлт үзүүлж, нөөцөлсөн махыг хөнгөлөлттэй үнээр худалдан борлуулах арга хэмжээг зохион байгуулсан. Арилжааны банкны шалгуурт тэнцсэн “Баатарууд Тэнгэр”, “Дархан мийт фүүдс”, “Сүхбаатар мах маркет” ХХК-иуд 4.0 мянган тн мах бэлтгэснийг нийслэлийн хүн амын хүнсний хэрэгцээнд 2019 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс нийлүүлж, нийслэлийн 8 дүүргийн хүнсний 137 дэлгүүрээр дамжуулан үхрийн ястай мах 7200 төг/кг, хонины ястай мах 6000 төг/кг, ямааны ястай мах 5500 төг/кг үнээр худалдаалсан нь зах зээл дэх жижиглэнгийн үнээс 16-45 хувиар хямд байв.	Үнэлэх боломжгүй
2. Хүнсний шим тэжээллэг чанарыг сайжруулах, зохистой хэрэглээг дэмжих зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ						
11	2.1. Хүнсний хэрэглээ, шим тэжээлийн боловсролыг дээшлүүлэх, зохистой хооллох дадлыг төлөвшүүлэх чиглэлээр “Ээжийн сонголт – Эрүүл хүнс” болон “Өглөөний цай” хөдөлгөөн өрнүүлэх	2019 - 2023			“Ээжийн сонголт – Эрүүл хүнс” болон “Өглөөний цай” хөдөлгөөнийг зохион байгуулах удирдамж, хэрэгжилтийг зохицуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг ХХААХҮ-ийн сайдын 2019 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А-329 дүгээр тушаалаар батлуулж, хөдөлгөөнүүдийн нээлтийг Дэлхийн хүнсний өдрийг тохиолдуулан Сүхбаатарын талбайд зохион байгуулав. Хөдөлгөөнүүдийг нийгмийн сүлжээг ашиглах зохион байгуулах бөгөөд хүнсний хэрэглээ, шим тэжээлийн боловсролыг дээшлүүлэх, зохистой хооллох дадлын төлөвшүүлэх чиглэлд хийгдсэн судалгааны ажлуудыг татан төвлөрүүлж байна. Эдгээр хөдөлгөөнийг 2019-2023 онд өрнүүлднэ.	Үнэлэх боломжгүй

12	2.2. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол олгох сургалтын байгууллагын хичээлийн хөтөлбөрт “Хоол, хүнсний зөв сонголт, зохистой хэрэглээ” агуулгыг тусгаж, хэрэгжүүлэх	2019 - 2023			Төлөвлөгөөнд тусгагдсан хугацаа болоогүй	Үнэлэх боломжгүй
13	2.3. Хүнсний бүтээгдэхүүний шошго, хоолны цэсэнд тухайн бүтээгдэхүүний шим тэжээлийн үзүүлэлтийг тусгаж хэвшүүлэх	2019 - 2023			Төлөвлөгөөнд тусгагдсан хугацаа болоогүй.	Үнэлэх боломжгүй
14	2.4. Хүнсний бодит хэрэглээний судалгааг улирлаар бүсчлэн хийж, зөвлөмж боловсруулах	2019 - 2023			Төлөвлөгөөнд тусгагдсан хугацаа болоогүй.	Үнэлэх боломжгүй
15	2.5. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний найрлагын хүснэгтийг 3 жил тутамд шинэчлэх	2019 - 2023			Хүнсний найрлагын хүснэгтийг шинэчлэн боловсруулах ажлыг ХХААХҮЯ-наас захиалан ШУТС-ийн санхүүжилтээр 2017 оноос эхлүүлэн ШУТИС-ийн баг гүйцэтгэхээр гэрээ байгуулан ажиллаж, зарим хүнсний бүтээгдэхүүний найрлага, шим тэжээлийн үзүүлэлтийг шинэчлэх ажлын хүрээнд лабораторид шинжлүүлэх ажлыг хийгээд үр дүнг тайлагнахаар ажиллаж байна. 2020 онд үргэлжлүүлэн гүйцэтгэхээр гэрээ байгуулж, тайланг 2020 онд хүлээлгэн өгнө. Энэхүү ажлын хүрээнд хүнсний бүтээгдэхүүний шим тэжээлийн найрлагын программыг хийн, практикт нэвтрүүлсэн.	Үнэлэх боломжгүй
16	2.6. Цэцэрлэг, сургуулийн хүүхдийн хоолны жор, орцын зохистой харьцааг хүн амын физиологийн зөвлөмж хэмжээтэй уялдуулан тогтоож, мөрдөх	2019 - 2023			-Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье арга хэмжээг улсын хэмжээнд анх удаа /2018-2019он/ зохион байгуулж, 21 аймаг, нийслэлээс 100 гаруй цэцэрлэг өөрсдийн сайн дураар оролцсон. Энэхүү ажлын хүрээнд цэцэрлэгийн захирал, тогооч, эмч нарт зориулсан давсны агууламжийг багасгасан хоолны цэсээр хоол хийх онол, практикийн сургалтыг нийслэл, хөдөө орон нутагт 30 гаруй удаа зохион байгуулагч байгууллагууд, аймгийн ХХААГ-тай хамтран зохион байгуулж, мэдээлэл, сургалчилгааг хэвлэл, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр тотмол явуулсан. Үүний үр дүнд арга хэмжээнд хамрагдсан цэцэрлэгүүд давс багатай хоолны цэс, технологийн картыг батлуулан ажиллаж хэвшнээр цэцэрлэгийн хүүхдийн 10-аас дээш нэр төрлийн хоолны давсны агууламжийг дунджаар 40% хүртэл бууруулсан. - Ерөнхий	Үнэлэх боломжгүй

					боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 10.дугаар зүйлд заасны дагуу НЭМҮТ-тэй хамтран сургуулийн хүүхдийн хоолны 1 сарын цэсийг боловсруулах ажилд мэргэжил аргагүйгээр ханган хамтран ажиллаж байна.	
17	2.7. Эрүүл мэндийг дэмжих үйлчлэлтэй хүнсний дотоодын үйлдвэрлэлийг гадаад улс, олон улсын байгууллагын хөтөлбөр, төсөлд хамруулах замаар дэмжих	2019 - 2023			1. Эрүүл мэндийг дэмжих үйлчлэлтэй хүнсний үйлдвэр байгуулах ТЭЗҮ, төслийн танилцуулгыг англи хэл дээр бэлтгэж “Эрүүл хүнс – Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн зөвлөлдөх уулзалтын үеэр гадаад улс, олон улсын байгууллагуудад санхүүжилт татах зорилгоор танилцуулав. 2. Эрүүл мэндийг дэмжих үйлчлэлтэй хүнс буюу баяжуулсан хүнсний үйлдвэрлэлийг дэмжих, баяжуулсан хүнсний дотоодын үйлдвэрийг дэмжих зорилгоор НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтээр Баяжуулсан хүнсний тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Эрүүл мэндийн яам болон Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран "Баяжуулсан буудайн гурил техникийн ерөнхий шаардлага. MNS 6812-2019", "Буудайн гурилыг баяжуулагч бэлдмэл. Техникийн ерөнхий шаардлага. MNS 6811-2019", "Хүнсний зориулалтын иоджуулсан давс. Техникийн ерөнхий шаардлага. MNS 5046-2019" стандартын төслүүдийг боловсруулж, батлуулсан. Мөн "Баяжуулсан хүнс болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээний загвар, хэрэглэх журам", "Баяжуулсан хүнс үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх журам"-ыг 2019 онд батлуулж, журмын хэрэгжилтийг ханган гурил, давс үйлдвэрлэгч ААНБ-тай хамтран ажиллаж, мэргэжил аргайгүйгээр ханган ажиллаж байна. - Зохицуулах үйлчилгээтэй хүнсний тухай хуулийн үзэл баримтлалыг 2019 онд батлуулж, хуулийн төслийг боловсруулан, 2020 онд УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	Үнэлэх боломжгүй
18	2.8. Сахар чихрийн зүйл, транс тос, давсны агууламж өндөртэй бүтээгдэхүүний нийлүүлэлт, хэрэглээг бууруулах арга хэмжээ авах	2019 - 2023			1. “Давс багатай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжжэ” аяныг 2019 онд улсын хэмжээнд зохион байгуулж, тус аянд хүнсний чиглэлийн 260 гаруй байгууллагыг хамруулав. Аянд хамрагдсан хүнс үйлдвэрлэгчид, нийтийн хоолны үйлчилгээ эрхлэгчид хоол, хүнсний бүтээгдэхүүнийхээ давсны агууламжийг 60 хүртэл хувиар	Үнэлэх боломжгүй

					бууруулж, нийгмийн хариуцлагын хүрээнд сургалт, сурталчилгаа зохион байгуулсан. 2. "Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье" 2-р шатны арга хэмжээг анх удаа улсын хэмжээнд 180 гаруй хоол, хүнс үйлдвэрлэгч ААНБ-ыг оролцуулан зохион байгуулсан. Арга хэмжээний хүрээний хүрээнд оны туршид хүнс хоол үйлдвэрлэгчдэд зориулсан сургалтыг нийслэл, орон нутагт зохион байгуулах, нийт хүн амд зориулсан мэдээлэл, сурталчилгааг хэвлэл, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлыг зохион байгуулж, зарим нэр төрлийн хоол, хүнсний давсны агууламжийг үе шаттайгаар бууруулах, шинжилгээнд хамруулах, давсны хэмжээг багасгасан хоолоор үйлчлэх ажлыг үйл ажиллагаандаа хэвшүүлэхэд мэдээлэл арга зүйгээр хангах ажлыг зохион байгуулж ажилласнаар зарим үр дүнд хүрсэн. Тухайлбал: 21 аймаг, нийслэл хотод хүнс, хоол үйлдвэрлэгчдийн 1000 гаруй төлөөллийг оролцуулан 40 гаруй онол, практикийн сургалт, нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, батлагдсан төлөвлөгөөний дагуу хоол, хүнсний бүтээгдэхүүн дэх давсны агууламжийг 3 удаагийн давтамжтай шинжлүүлснээр зарим нэр төрлийн хоол, хүнсний бүтээгдэхүүний давсны агууламжийг 40% хүртэл бууруулсан. Мөн арга хэмжээнд оролцсон цэцэрлэг, эмнэлэг 10-аас доошгүй нэр төрлийн хоолны давсны агууламжийг тогтмол бууруулж, давс багатай хоол үйлдвэрлэн, үйл ажиллагаандаа хэвшүүлсэн.	
